

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АГУУЛГА

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9. Зорилтот түвшин түүний гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	7
2.12. Шилэн дансны мэдээлэл	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал.....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	14
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТӨААТҮГ	Төрийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ГЕГ	Гаалийн ерөнхий газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.03.06 № 06/747
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хилийн 0119 дүгээр анги ТӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хилийн 0119 дүгээр анги ТӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Хилийн 0119 дүгээр анги ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Хилийн 0119 дүгээр анги ТӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Хилийн 0119 дүгээр анги ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг ангийн захирагч, хурандаа Г.Алтангэрэл Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн цаашид мөнгөн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, анхан шатны баримтын бүрдүүлэлтэд анхаарч ажиллах, үргүй зардал гаргахгүй байх, ашиглалтын хугацаа дууссан биет бус хөрөнгийг холбогдох хууль, заавар журмын дагуу шийдвэрлүүлэх, зорилтот түвшинг үндэслэлтэй төлөвлөж, хэрэгжилтийг хангаж ажиллах бүртгэл тайлагналыг сайжруулах, байгууллагын дотоод хяналтын системийг сайжруулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хилийн 0119 дүгээр анги” ТӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Хилийн 0119 дүгээр анги ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Тус анги нь санхүүгийн тайлангаа НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн баталсан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 02-ноос 2020 оны 02 дугаар сарын 13-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдөр эцэслэн баталгаажуулж, ангийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын захиалгаар “Баянсуварга Аудит” ХХК-ийн аудитор Н.Бат-Оюун, Э.Баярсайхан нар хариуцаж хэрэгжүүлэв.

Хилийн 0119 дүгээр анги ТӨААТҮГ нь 2019 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн МН/02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хилийн 0119 дүгээр анги ТӨААТҮГ-нь Хил хамгаалалтын зориулалттай барилга байгууламж, объектуудад их засвар хийх, төрийн нууцын зэрэглэлтэй барилга, объектыг батлагдсан зураг, төсөв, стандарт, гэрээний дагуу шинээр барих ажлыг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэх үндсэн зорилго дэвшүүлэн ажиллажээ.

Хилийн 0119 дүгээр анги ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Барилга угсралтын ажил
- Гадаад худалдаа

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- 2019 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Хил хамгаалах байгууллагын ажил дүгнэх журам”-уудад шинэчлэлт өөрчлөлт хийсэн.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус ангийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хилийн 0119 дүгээр анги ТӨААТҮГ- нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Интерактив Би Ай компанийн боловсруулсан “Diamond, Payroll” программ хангамжийг ашигладаг байна.

Хилийн 0119 дүгээр анги ТӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хилийн 0119 дүгээр анги ТӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 15 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангаарх нийт орлогын дүнг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 3.5 сая төгрөгөөс тооцон 69.5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн Орлогын дэлгэрэнгүй тайлангаарх нийт орлогын 2 хувиар тооцон 180.8 сая төгрөгөөр тогтоов.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хилийн 0119 дүгээр анги ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,052.7 сая төгрөгөөр буюу 27.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	70.1	5,235.3	5,165.2
Авлага	951.2	1,095.5	144.3
Бараа материал	2,545.5	3,309.6	764.0
Үндсэн хөрөнгө	1,172.3	1,151.5	(20.9)
Нийт хөрөнгө	4,739.1	10,791.8	6,052.7
Өр төлбөр	749.6	1,754.5	1,004.9
Урьдчилж орсон орлого	376.2	5,045.0	4,668.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,613.3	3,992.3	379.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,739.1	10,791.8	6,052.7

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр, урьдчилж орсон орлого, эздийн өмчийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Тайлант оны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 5,165.2 сая төгрөгөөр өссөн нь Гаалийн Ерөнхий Газрын даргатай байгуулсан №ШН/2019 тоот гэрээний урьдчилгаа төлбөр 5,000.0 сая төгрөг Сангийн яамны төрийн сангаас шилжиж ирсэн, бэлнээр тушаагдсан 95.1 сая төгрөгийн бусад орлогоос орлого цугларснаас шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 144.3 сая төгрөгөөр өссөн нь 3 байгууллагын барилгын чанарын баталгааны 5.0 хувь 369.8 сая төгрөгийг Сангийн яамны барьцааны байршуулсантай холбоотой байна. Авлага дансны үлдэгдэлд 2016-2019 онуудад үүссэн, 2016 онд орон сууц худалдан борлуулсан, хувь хүнээс авах 635.2 сая, 5 байгууллагаас авах бараа ажил үйлчилгээний орлого 86.1 сая, бусад байгууллагаас авах 4.4 сая төгрөгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 764.0 сая төгрөгөөр өссөн нь 2020 онд борлуулагдах 764.0 сая төгрөгийн 15 нэр төрлийн хөрөнгийг бүртгэснээс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдан борлуулах зорилгоор 2015-2016 онд ашиглалтад орсон 743.4 сая төгрөгийн 59 ширхэг автомашины зогсоол, 9 нэр төрлийн 830.6 сая төгрөгийн хөрөнгийг тус тус бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 20.9 сая төгрөгөөр буурсан нь ТӨБЗГ-ын Н/11 тогтоол, ХХЕГ-ын даргын Н/64 тоот тушаалаар хөрөнгө акталж данснаас хасах тухай тушаалаар 20 нэр төрлийн 11.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассан байна.

ТӨБЗГ-ын Н/20-14, ХХЕГ-ын даргын Н/62 тоот тушаалаар Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох тухай ” тушаалаар 27 нэр төрлийн үндсэн хөрөнгийг 21.8 сая төгрөгөөр дахин үнэлсэн байна.

Биет бус хөрөнгө 6.0 сая төгрөгөөр өссөн нь дахин үнэлгээ хийгдсэнээс шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,004.9 сая төгрөгөөр өссөн нь банкны богино хугацаат зээл /шугамын зээлийн өр/ 450.0 сая төгрөгөөр, барилгын ажлын гүйцэтгэлийн санхүүжилт 12 дугаар сарын сүүлчээр хойшилж орсноос туслан гүйцэтгэгч байгууллага болон татварын байгууллагад төлөх 554.9 сая төгрөгийн өглөг үүссэн зэргээс шалтгаалжээ.

Урьдчилж орсон орлого өмнөх оноос 4,668.8 сая төгрөгөөр өссөн нь 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдөр ГЕГ-ын даргатай байгуулсан №ШН/2019 тоот гэрээний урьдчилгаа төлбөр 5,000.0 сая төгрөг 2019 оны 12 сарын 30-ны өдөр Сангийн яамны төрийн сангаас орж ирсэн.

Засгийн газрын оролцоо/эздийн өмч дансны үлдэгдэл 3,992.3 сая төгрөг болж өссөн нь хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 21.8 сая, тайлант үеийн ашиг 357.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

2.9. Зорилтот түвшин түүний гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Тус ХХЕГ-ын хилийн цэргийн командлагч /Ерөнхий менежер/-тай байгуулсан үр дүнгийн гэрээ, бизнес төлөвлөгөөнд борлуулалтын орлогыг 2,987.9 сая төгрөг, борлуулсан бүтээгдэхүүний өртгийг 2,376.7 сая төгрөг, удирдлагын зардлыг 493.7 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны ашгийг 67.5 сая төгрөг байхаар тус тус баталсан байна.

Тус анги 2019 онд Хилийн анги заставын барилга угсралт, их засварын ажлаас 7,351.4 сая төгрөг, ХХЕГ-ын захиалгаар нийлүүлсэн хил хамгаалалтын тусгай хэрэгслийн орлого 1,496.4 сая төгрөг, түрээсийн орлого 49.4 сая төгрөг, Архивын ерөнхий газарт халаалт, дулаан борлуулсан орлого 100.9 сая төгрөг, хөрөнгө борлуулсан орлого 34.0 сая төгрөг, хүү болон бусад орлого 8.7 сая төгрөг, нийт 9,040.8 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Тайлант оны борлуулсан бүтээгдэхүүний өртөгт 8,011.6 сая төгрөг удирдлагын зардалд 403.7 сая төгрөг, үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардалд 104.7 сая төгрөг, бусад магадалшгүй ажлын зардал 112.4 сая төгрөг нийт 8,632.4 сая төгрөгийг зарцуулсан байна. Тайлант онд 357.2 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Ерөнхий удирдлагын зардалд 495.7 сая төгрөг ,бусад магадалшгүй зардалд 50.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр удирдлагын зардалд 508.4 сая төгрөг,бусад магадалшгүй зардал 112.4 сая төгрөг тус тус зарцуулж удирдлагын зардал 12.7 сая төгрөгөөр, бусад магадалшгүй ажлын зардал 62.4 сая төгрөгөөр хэтэрсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 15 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 2 эрсдэл тодорхойлж нийт 17 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 299.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 248.2 сая төгрөгийн алдааг залруулж, 51.5 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө. Үүнд:

1. Тус анги 2 нэр төрлийн 30.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг буруу ангилан бараа материалын дансанд бүртгэсэн, ТӨБЗГ-ын 2017 оны акталж данс бүртгэлээс хасах шийдвэрийг хэрэгжүүлээгүй анхны өртөгтэй 1.0 сая төгрөгийн өртөгтэй Зил 555 маркийн тээврийн хэрэгслийг данс бүртгэлээс хасаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар”-ыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

2. Санхүүгийн тайлангийн удирдлагын зардалаар тайлагнасан нийт 724.5 сая төгрөгөөс 216.1 сая төгрөгийг дансны ангилал буруу бүртгэж тайлагнасан байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн орлого үр дүнгийн тайланд залруулга хийсэн.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тус ангийн барилгын талбайд ашиглагдаж байгаа хөрөнгийн ашиглалтын байдал болон санхүүгийн бүртгэл тайланд тайлагнагдаж байгаа барилгын бараа материалын талаарх байдлыг талбайн инженерүүдийн анхан шатны бүртгэл хөтлөлттэй баримтжуулан авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Хилийн 0119 дүгээр анги ТӨААТҮГ-ын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 5 төрлийн 137 мэдээллээс 124 мэдээллийг хугацаанд нь, 13 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 5.6 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосныг барагдуулсан

Нийт 4 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна. Зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хилийн 0119 дүгээр анги ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хилийн 0119 дүгээр анги ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг СТОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Хилийн 0119 дүгээр анги ТӨААТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

- 3.1.1 Илрүүлэлт: Кассын 2019 оны анхан шатны баримт, гүйлгээний журналаас үзэхэд тайлант онд гэрээт 24 аж ахуйн нэгж, хувь хүнд 10.0 саяас дээш төгрөгийн үнийн дүнтэй төлбөр тооцоог харилцах дансаар хийгээгүй бэлэн мөнгөөр гаргасан, касст байх бэлэн мөнгө 10.0 сая төгрөгөөс 21.2 сая төгрөгийн хэтэрсэн үлдэгдэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг дэх “Кассын үйл ажиллагааны журам”-ын 2-т ...”жижиг мөнгөн сангийн дээд хязгаар 10 сая төгрөг байна гэж заасан байна”, 4-т “анги нь 10 сая хүртэлх үнийн дүн бүхий бараа ажил үйлчилгээний төлбөрийн гүйлгээг бэлэн мөнгөөр гүйцэтгэнэ. Энэ тогтоосон хэмжээнээс хэтэрсэн болон байнга харилцан гүйлгээ хийдэг бол харилцах дансаар дамжуулан төлбөр тооцоо хийнэ”, гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн Үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- 3.1.2 Эрсдэл: Мөнгөн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт суларч үргүй зардал гаргах, бэлэн мөнгө ашиглах, шамшигдуулах
- 3.1.3 Өгсөн зөвлөмж: Цаашид Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн “Кассын үйл ажиллагааны журам”-д заасан бэлэн мөнгөний гүйлгээний дээд хязгаарыг мөрдөж, кассын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах.
- 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээ авч, хариу мэдэгдэнэ

3.2 Зардлын данстай холбоотой асуудал

- 3.2.1 Илрүүлэлт: Кассын зарлагын тайлангаар гарсан гүйлгээг шалгахад гадаад, дотоод томилолтын зардалд нэр бүхий хорин есөн хүнд 26.7 сая төгрөгийг олгож гүйцэтгэлийн тайлан тооцоход анхан шатны баримт бүрдүүлэлт хангалтгүй “Мөнгөн урьдчилгааны тайлан”-ийн маягтыг хөтлөөгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл

болно”, 2017 оны Сангийн сайдын 347 дугаар тушаалаар баталсан НХМаягт ТМ-2 “Мөнгөн урьдчилгааны тайлан” анхан шатны маягтыг нөхөх заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн ба Үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- 3.2.2 Эрсдэл: Санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд зардал буруу илэрхийлэгдэх
- 3.2.3 Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдүүлэлтэд анхаарч ажиллах, анхан шатны баримтыг үндэслэн ажил гүйлгээг үнэн зөв бүртгэх. Цаашид Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох журам, зааврыг мөрдөж, цаашид дотоод хяналтыг сайжруулж ажиллах;
- 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээ авч, хариу мэдэгдэнэ

3.3 Бараа материалын данстай холбоотой асуудал

- 3.3.1 Илрүүлэлт: Биет бус хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 3.6 сая төгрөгийн анхны үнэтэй 2016 оноос хойш ашиглагдаагүй, хэрэгцээ шаардлага хангахгүй “Поверсофт” программыг данс бүртгэлээс хасах арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ.” Гэж заасныг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ, хэмжилт, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.
- 3.3.2 Эрсдэл: Хөрөнгийг бодит үнэ цэнээр нь бүртгээгүй байх, ашиглалтын шаардлага хангахгүй хөрөнгийг бүртгэлээс хасаагүй байх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, холбогдох ууль, журам, зааврыг мөрдөж ажиллаагүй байх;
- 3.3.3 Өгсөн зөвлөмж: Цаашид ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг холбогдох хууль, заавар журмын дагуу шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах.
- 3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээ авч, хариу мэдэгдэнэ.

3.4 Шилэн данстай холбоотой асуудал

- 3.4.1 Илрүүлэлт: Тус анги 2019 онд Шилэн дансны цахим хуудсанд 5 төрлийн 137 мэдээллээс 13 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.4-д “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.
- 3.4.2 Эрсдэл: Хуулийн заалт зөрчигдөж дотоод хяналт суларч, удирдлага, харилцагч нар мэдээллээр хангагдахгүй байх
- 3.4.3 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хэрэгжилтийг хангаж санхүүгийн тайлан, төсөв, гүйцэтгэл, бусад мэдээ мэдээллийг хугацаанд нь цахим мэдээллийн санд байршуулж ажиллах;

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээ авч, хариу мэдэгдэнэ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан**4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,440,952,698.63</u>	<u>9,640,380,178.66</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	70,085,979.47	5,235,317,818.25
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	27,987,765.60	31,222,917.30
31110	Төгрөг	27,987,765.60	31,222,917.30
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	42,098,213.87	5,204,094,900.95
3121	Төгрөг	42,098,213.87	5,204,094,900.95
31213	Арилжааны банк дахь харилцах	42,098,213.87	5,204,094,900.95
33	АВЛАГА	825,319,334.38	1,009,342,115.73
33401	Дансны авлага /ТӨҮГ/	819,494,823.74	635,259,657.00
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	5,198,934.59	4,282,107.73
3351	Байгууллагаас авах авлага	625,576.05	369,800,351.00
34	УРЬДЧИЛГАА	125,850,710.31	86,150,493.04
34600	Урьдчилж гарсан зардал	125,850,710.31	86,150,493.04
35	БАРАА МАТЕРИАЛ	1,764,347,384.78	2,566,169,751.64
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	1,497,338,064.42	1,436,693,468.12
35300	Бэлэн бүтээгдэхүүн	113,284,718.18	113,284,718.18
354	Хангамжийн материал	153,724,602.18	1,016,191,565.34
35470	Бусад хангамжийн материал	153,724,602.18	1,016,191,565.34
36	НӨӨЦИЙН БАРАА	781,200,000.00	743,400,000.00
36900	Борлуулах зорилгоор эзэмшиж буй бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	781,200,000.00	743,400,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,172,340,299.26</u>	<u>1,151,473,823.53</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,172,340,299.26	1,151,473,823.53
392	Биет хөрөнгө	1,130,006,168.38	1,105,473,823.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	714,478,195.31	785,371,641.89
39202	Хуримтлагдсан элэгдэл	0.00	88,328,529.46
39203	Авто-тээврийн хэрэгсэл	557,235,980.00	554,875,980.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	273,666,858.91	309,137,196.38
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	156,335,126.40	176,118,734.49
39206	Хуримтлагдсан элэгдэл	58,092,801.94	46,684,120.23
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	32,703,314.79	31,645,996.61
39208	Хуримтлагдсан элэгдэл	17,718,782.81	17,884,283.13
39214	Бусад үндсэн хөрөнгө	66,657,375.14	57,346,004.96
39215	Хуримтлагдсан элэгдэл	47,925,379.60	37,850,405.22
393	Биет бус хөрөнгө	42,334,130.88	46,000,000.00
39301	Программ хангамж	12,928,000.00	9,600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	10,593,869.12	3,600,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	40,000,000.00	40,000,000.00
39405	Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨҮГ/		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,613,292,997.89</u>	<u>10,791,854,002.19</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,125,858,359.13</u>	<u>6,799,547,168.18</u>

41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,125,858,359.13	6,799,547,168.18
412	Богино хугацаат зээлийн өглөг	300,000,000.00	750,000,000.00
41216	Арилжааны банк	300,000,000.00	750,000,000.00
413	Өглөг	449,631,247.13	1,004,547,168.14
4136	Бусад өглөг	449,631,247.13	1,004,547,168.14
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	114,500,973.82	351,201,046.43
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	335,130,273.31	653,346,121.71
414	Урьдчилж орсон орлого	376,227,112.00	5,045,000,000.04
41440	Бусад урьдчилж орсон орлого	376,227,112.00	5,045,000,000.04
41450	Төрийн өмчийн үйлдвэр, аж ахуйн газар		
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,613,285,349.07</u>	<u>3,992,306,834.01</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,613,285,349.07	3,992,306,834.01
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,086,125,930.36	1,086,125,930.36
51101	Өмч: - төрийн	877,779,515.45	877,779,515.45
51105	Нэмж төлөгдсөн капитал	208,346,414.91	208,346,414.91
512	Хуримтлагдсан үр дүн	2,093,147,721.41	2,450,389,206.35
51210	Өмнөх үеийн үр дүн	2,091,856,899.93	2,093,147,721.41
51220	Тайлант үеийн үр дүн	1,290,821.48	357,241,484.94
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	434,011,697.30	455,791,697.30
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,739,143,708.20</u>	<u>10,791,854,002.19</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	3,426,971,919.78	8,989,986,404.72
2	Борлуулалтын өртөг	2,933,847,299.40	8,011,619,659.97
3	Нийт ашиг (алдагдал)	493,124,620.38	978,366,744.75
4	Түрээсийн орлого	18,818,181.81	25,090,909.09
5	Хүүгийн орлого	690,580.45	1,472,407.00
8	Бусад орлого	26,934,326.34	24,304,545.64
10	Ерөнхий ба удирдлагын зардал	458,294,510.38	508,443,619.25
12	Бусад зардал	38,306,518.72	112,411,914.57
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(31,134,340.00)	(1,592,179.00)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(6,141,813.94)	2,638,302.33
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	5,690,525.94	409,425,195.99
19	Орлогын татварын зардал	4,399,704.46	52,183,711.05
20	Татварын дараах ашиг (алдагдал)	1,290,821.48	357,241,484.94
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,290,821.48	357,241,484.94
27	Орлогын нийт дүн	1,290,821.48	357,241,484.94
28	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайланТайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	5,387,566,817.74	16,008,639,788.72
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	5,365,914,309.58	16,008,639,788.72
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
1.1.4	Бусад мөнгөн орлого	21,652,508.16	-
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,336,426,773.10	11,192,094,895.30
1.2.1	Ажиллагсдад төлсөн	512,626,626.00	641,552,381.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	50,706,406.84	91,133,158.98
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	3,782,280,671.82	7,291,049,736.05
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	12,890,661.23	20,038,166.30
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	12,157,221.82	56,159,773.87
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	699,261,002.97	525,994,324.46
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	1,699,179.00	1,675,597.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	264,805,003.42	2,564,491,757.64
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	51,140,044.64	4,816,544,893.42
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	690,580.45	1,472,407.00
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.5	Хүлээн авсан хүүгийн орлого	690,580.45	1,472,407.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	690,580.45	1,472,407.00
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	300,000,000.00	1,050,000,000.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	300,000,000.00	1,050,000,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	367,471,993.92	702,785,461.64
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	367,471,993.92	702,785,461.64
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(67,471,993.92)	347,214,538.36
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(15,641,368.83)	5,165,231,838.78
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	85,727,348.30	70,085,979.47
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	70,085,979.47	5,235,317,818.25

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,046,125,930.36	-	2,091,856,899.93	3,137,982,830.29
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,046,125,930.36	0.00	2,091,856,899.93	3,137,982,830.29
3	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	434,011,697.30	-	434,011,697.30
4	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	40,000,000.00	-	-	40,000,000.00
5	Тайлант үеийн үр дүн	-	-	1,290,821.48	1,290,821.48
6	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,086,125,930.36	434,011,697.30	2,093,147,721.41	3,613,285,349.07
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,086,125,930.36	434,011,697.30	2,093,147,721.41	3,613,285,349.07
9	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	21,780,000.00	-	21,780,000.00
12	Тайлант үеийн үр дүн	-	-	357,241,484.94	357,241,484.94
13	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,086,125,930.36	455,791,697.30	2,450,389,206.35	3,992,306,834.01

4.5. Зорилтот түвшин, түүний гүйцэтгэл

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
	НИЙТ ОРЛОГО	2,987,900,000.0	9,040,854,266.45	(6,052,954,266.5)
1	Үндсэн үйл ажиллагааны орлого	2,597,000,000.0	8,989,986,404.72	(6,392,986,404.7)
2	Хүүгийн орлого		1,472,407.00	(1,472,407.0)
3	Түрээсийн орлого	35,500,000.0	25,090,909.09	10,409,090.9
3.1	Бусад орлого	355,400,000.0	24,304,545.64	331,095,454.4
	НИЙТ ЗАРДАЛ	,922,400,000.0	8,632,475,193.79	(5,710,075,193.8)
1	Бүтээгдэхүүний өртөг	2,376,700,000.0	8,011,619,659.97	(5,634,919,660.0)
1.1	Барилга угсралт, засвар үйлчилгээний өртөг	2,263,100,000.0	7,951,119,660.0	(5,688,019,660.0)
1.2	Архивын уурын зуухны халаалтын өртөг	113,600,000.0	60,500,000.0	53,100,000.0
2	Удирдлагын зардал	495,700,000.0	508,443,619.25	(12,743,619.3)
2.1	Цалингийн зардал	300,000,000.0	299,493,603.93	506,396.1
2.2	Нийгмийн даатгалын шимтгэл	35,000,000.0	34,064,102.18	935,897.8
2.3	Засвар үйлчилгээний зардал	10,000,000.0	7,198,000.00	2,802,000.0
2.4	Ашиглалтын зардал	15,500,000.0	15,385,076.00	114,924.0
2.5	Албан томилолтын зардал	8,000,000.0	6,735,772.00	1,264,228.0
2.6	Сургалт, зар сурталчилгааны зардал	2,000,000.0		2,000,000.0
2.6	Шуудан холбооны зардал	3,000,000.0	1,994,496.36	1,005,503.6
2.7	Шатахууны зардал	13,000,000.0	11,904,312.26	1,095,687.7
2.8	Газрын төлбөр	10,200,000.0	10,212,400.00	(12,400.0)
2.9	Мэргэжлийн үйлчилгээний зардал	6,000,000.0	6,024,000.00	(24,000.0)
2.10	Бичиг хэргийн зардал	8,000,000.0	8,764,797.23	(764,797.2)
2.11	Татварын зардал	5,000,000.0	48.00	4,999,952.0
2.12	Хангамжийн материал		291,403.09	(291,403.1)
2.15	Даатгалын зардал		1,675,597.00	(1,675,597.0)
2.16	Бусад зардал /Элгэдэл/	80,000,000.0	104,700,011.20	(24,700,011.2)
3	Бусад зардал	50,000,000.0	112,411,914.57	(62,411,914.6)
3.1	Бусад магадлашгүй зардал	50,000,000.0	112,411,914.57	(62,411,914.6)
4	ТӨСӨВЛӨСӨН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН			
4.1	Үйл ажиллагааны орлого	2,987,900,000.0	9,040,854,266.5	(6,052,954,266.5)
4.2	Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөг	2,376,700,000.0	8,011,619,660.0	(5,634,919,660.0)
4.3	ҮХ данснаас хассаны олз		2,638,302.33	(2,638,302.3)
4.4	Удирдлагын зардал	493,700,000.0	508,443,619.25	(14,743,619.3)
4.5	Бусад зардал	50,000,000.0	112,411,914.57	(62,411,914.6)
4.6	Гадаад валютын ханшын зөрүүгийн гарз		1,592,179.00	(1,592,179.0)
4.7	Татвар төлөхийн өмнөх ашиг	67,500,000.0	409,425,196.0	(341,925,196.0)
4.8	Орлогын татварын зардал	6,750,000.0	52,183,711.05	(45,433,711.1)
4.9	Татварын дараах ашиг /алдагдал/	60,750,000.0	357,241,484.9	(296,491,484.9)

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	“Хилийн 0119 дүгээр анги” ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2020.03.01			САГ-2020/57/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	“Хилийн 0119 дүгээр анги” ТӨААТҮГ		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Кассын 2019 оны анхан шатны баримт, гүйлгээний журналаас үзэхэд тайлант онд гэрээт 24 аж ахуйн нэгж, хувь хүнд 10.0 саяас дээш төгрөгийн үнийн дүнтэй төлбөр тооцоог харилцах дансаар хийгээгүй бэлэн мөнгөөр гаргасан, кассат байх бэлэн мөнгө 10.0 сая төгрөгөөс 21.2 сая төгрөгийн хэтэрсэн үлдэгдэлтэй байна	21.2	Зөвлөмж	Ангийн захирагч, хурандаа Санхүү тасгийн дарга ерөнхий нягтлан бодогч	Г.Алтангэрэл Ж.Өлзийдэлгэр
2	Кассын зарлагын тайлангаар гарсан гүйлгээг шалгахад гадаад, дотоод томилолтын зардалд нэр бүхий хорин есөн хүнд 26.7 сая төгрөгийг олгож гүйцэтгэлийн тайлан тооцоход анхан шатны баримт бүрдүүлэлт хангалтгүй “Мөнгөн урьдчилгааны тайлан”-ийн маягтыг хөтлөөгүй байна.	26.7	Зөвлөмж	Ангийн захирагч, хурандаа Санхүү тасгийн дарга ерөнхий нягтлан бодогч	Г.Алтангэрэл Ж.Өлзийдэлгэр
3	Биет бус хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 3.6 сая төгрөгийн анхны үнэтэй 2016 оноос хойш ашиглагдаагүй, хэрэгцээ шаардлага хангахгүй “Поверсофт” программыг данс бүртгэлээс хасах арга хэмжээ авч ажиллаагүй байна.	3.6	Зөвлөмж	Ангийн захирагч, хурандаа Санхүү тасгийн дарга ерөнхий нягтлан бодогч	Г.Алтангэрэл Ж.Өлзийдэлгэр
4	2019 онд Шилэн дансны цахим хуудсанд 5 төрлийн 137 мэдээллээс 13 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	-	Зөвлөмж	Ангийн захирагч, хурандаа Санхүү тасгийн дарга ерөнхий нягтлан бодогч	Г.Алтангэрэл Ж.Өлзийдэлгэр
5	Тус анги 357.2 сая төгрөгийн ашигтай ажилласан боловч ерөнхий удирдлагын зардалд 508.4 сая төгрөг, бусад магадалшгүй ажлын зардал 112.4 сая төгрөг зарцуулсан нь төлөвлөснөөс 75.1 сая төгрөгөөр хэтэрсэн байна. Энэ нь 2019 онд ХХЕГ-ын дарга /Ерөнхий менежер/-тай байгуулсан үр дүнгийн гэрээний хавсралт “Хилийн 0119 дүгээр ангийн 2019 оны бизнес төлөвлөгөө”-г зөрчиж байна	-	Албан шаардлага	Ангийн захирагч, хурандаа Санхүү тасгийн дарга ерөнхий нягтлан бодогч	Г.Алтангэрэл Ж.Өлзийдэлгэр
	Нийт дүн	51.5			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 09 № 02/108

Улаанбаатар хот

СМГ-2020/57/СТА ТӨЧГ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Хилийн 0119 дугаар анги" ТӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Тус анги 357.2 сая төгрөгийн ашигтай ажилласан боловч ерөнхий удирдлагын зардалд 508.4 сая төгрөг, бусад магадалшгүй ажлын зардал 112.4 сая төгрөг зарцуулсан нь төлөвлөснөөс 75.1 сая төгрөгөөр хэтэрсэн байна. Энэ нь 2019 онд ХХЕГ-ын дарга /Ерөнхий менежер/-тай байгуулсан үр дүнгийн гэрээний хавсралт "Хилийн 0119 дүгээр ангийн 2019 оны бизнес төлөвлөгөө"-г зөрчиж байна.

Энэ нь санхүүгийн тайлагналын "үнэн зөв байдал" батламж мэдэгдэл болон Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д "төсвийн тогтвортой байдлыг хангасан байх", 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх заалтыг тус тус зөрчиж байна.

"Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Дээр дурдсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2020 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг "Хилийн 0119 дүгээр анги" ТӨААТҮГ-ын захирагч, хурандаа Г.Алтангэрэл, Санхүүгийн тасгийн дарга, ерөнхий нягтлан бодогч Ж.Өлзийдэлгэр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА

БИЧСЭН:

САГ-ЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТОР Д.ЦЭГМИДДОРЖ

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
"БАЯН СУВАРГА АУДИТ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ С.ДОЛЖИНСҮРЭН
АУДИТОР Ж.ТУНГАЛАГТУЯА

ЗӨВШӨӨРСӨН:

ХИЛИЙН 0119 ДҮГЭЭР АНГИ ТӨААТҮГ-ЫН
ЗАХИРАГЧ, ХУРАНДАА

Г.АЛТАНГЭРЭЛ
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

Ж.ӨЛЗИЙДЭЛГЭР

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай санхүүгийн төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хургуулна" гэж заасны дагуу харилцагч албан тушаалтанд харилцаа тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Richir_Kherem\Alban Shaardlaga\2020\03\05AG3.Docx

001080372